



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар АНЧ/8

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 6 нэгж талбарын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны а/528 дугаар захирамжийн Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай холбогдох заалт, 2020 оны А/446 дугаар захирамжийн хавсралтын аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100995

Аймгийн Засаг даргын 2020 оны 09
дугаар сарын 21-ны өдрийн 47/2020 дугаар
захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД
ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ² / газраас	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ² / газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт	3555739	Төрийн захиргааны байгууллага	4477	Өвөрхангай аймгийн Прокурорын газар	9044671	Төрийн захиргааны байгууллага	625	13 дугаар баг Гэндэн 3 дугаар гудамж 312 тоот	30 жил 7 сар
2					Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	9047646	Төрийн захиргааны байгууллага	468	13 дугаар баг Гэндэн 3 дугаар гудамж 310а тоот	30 жил 7 сар
3					Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	3553175	Төрийн захиргааны байгууллага	298	13 дугаар баг Гэндэн 3 дугаар гудамж 310 тоот	30 жил 7 сар
4					Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар	3555739	Төрийн захиргааны байгууллага	3086	13 дугаар баг Д.Пүрэвдоржийн 1 дүгээр гудамж 107 тоот	30 жил 7 сар
5	Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	9047646	Төрийн захиргааны байгууллага	1424	Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба	3553175	Төрийн захиргааны байгууллага	322	13 дугаар баг Гэндэн 3 дугаар гудамж 306 тоот	6 жил 6 сар
6					Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	9047646	Төрийн захиргааны байгууллага	1102	13 дугаар баг Гэндэн 3 дугаар гудамж 308 тоот	6 жил 6 сар